

НИЙТЛЭЛ, ТЭМДЭГЛЭЛ, МЭДЭЭЛЭЛ

Ч. Далай

«ХӨХ СУДАР» ЗОХИОЛЫН ТУХАЙ

Монголчууд эрт цагаас түүх намтраа тэмдэглэн бичиж ирсэн өв уламжлалтай бөгөөд түүний тод жишээ бол «Монголын нууц товчоо» ээрэг алдарт зохиолууд туурвигдан гарсан явдал юм. XIX зууны сүүлчээр төрөлх монгол хэлээр бичиж дуусгасан Инжинаашийн «Хөх судар»¹ бол тэдгээр уламжлалын нэг мөн. Монгол эрдэмтэн Инжинаашийн «Хөх судар» бичигдсэнээс хойш 90 жилийн нэг их урт биш хугацаа өнгөрч байгаа боловч уг зохиол түүхийн олон янзын ээдрээтэй нөхцөл байдалд монголчуудын дунд тархан дэлгэрсээр нэрд гарчээ. Иймээс монголын түүхийг судлахад чухал нэгэн сурвалж болох энэхүү зохиолыг сурвалжлан судлах явдал чухал шаардлагатай.

«Хөх судар» зохиолын тухай өгүүлэхийн өмнө тухайн үеийн тус бүс нутгийн нийгмийн байдал, зохиогчийн нийгмийн байр суурийг эрхбиш товчхон өгүүлэх нь зүйтэй болов уу.

XIX зууны сүүлч үеэс Манжийн эзэнт гүрний төрийн сүр хүчин эрс доройтож хятадын нөлөө төр улсынх нь бодлогод давамгайлж эхэлсэн байна. Манжийн үеийн «монгол нутагт үй олон хятад нүүлгэн суурьшуулахыг хориглосон» хууль хүчин төгөлдөр байхаа нэгэнт больж монгол нутгаар хятадууд нүүдэллэн ирж суурьших нь олширч, тэд очсон газартаа дур зоригоороо авирлан, хамгийн сайн үржил шимтэй малын билчээрийг хагалан тариа ногоо тарьж эхэлжээ.

Тэр үед Өвөр Монголын Зостын чуулганы Түмэд хошуу нь газар тариалан мал аж ахуй хосолсон аж ахуйтай байсан боловч хэрэг дээрээ хүн амын олонхи нь хятад болж, билчээрийн дийлэнх нь тариалангийн талбай болсон байлаа. Нэгэн зэрэг тус нутагт хятадын дээрэнгүй ажиллагаа ширүүсч монголчуудыг хүчээр уусган хятадчилах ажлыг шууд хийж эхэлсэн байжээ. Ийм нөхцөлд арга буюу нутгийн монголчууд хятадын дээрэнгүй ажиллагааг шүүмжлэн эсэргүүцсэн дуу шүлэг зохиох, хошин үгээр илэрхийлэх улмаар ном судар зохиох нь их болжээ. Тэдний нэг нь Инжинаашийн гэр бүл байлаа. Инжинаашийн эцэг Ванчинбал² тус хошууны дэд захирагч дээд тушаалын цэргийн дарга хүн байжээ. Хар там- хины дайны үед (1840 он) нутгийн цэргийг захиран хил хязгаар хамгаалах ажилд оролцон явжээ. Тэрээр цэрэг захирах ажлаас гадна ном судар цуглуулах дуртай, монголын түүхийг ихэд сонирхон судалж зохиол бичдэг байжээ. «Хөх судар» зохиолыг «Их Юан гүрний мандсан төрийн Хөх судар» нэртэйгээр эхний 8 бүлгийг нь бичиж дуусгажээ. Инжинааш³ бага насандаа баян хүний гэрт тансаг амьдралаар амьдарч

¹Инжинааш «Хөх судар», тэргүүн, дэд, гутгаар гурван дэвтэр; хуучин монголоор, бүгд 2161 тал хуудас. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 1957 он. Хөх хот.

²Ванчинбал (1795—1847) хятад нэр нь Бао Цзиньшань, 8 хүүхэд төрүүлсний 7-р хүү нь Инжинааш юм.

³Инжинааш нь Өвөр Монголын Зостын чуулганы Түмэд баруун хошуунд Төр Гэрэлтийн 17-р оны улаагчин тахиа жил (1837—5—15) төржээ. Багын нэр нь Хасчулуун, бичгийн нэр нь Инжинааш, хятад нэр нь Бао Хэньшань. 1892 оны 2-р сарын 25-ны өдөр 56 настай нас баржээ.

байсан тайж угсаатай хүн. Өөрийгээ Чингисийн 28-р үе гэж үздэг ажээ. Эцэг нас барсны дараа гэр бүлээрээ ядуурч, ах дүү наймуулаа амьдралын нилээд хүнд байдалд амьдарч, цөмөөрөө шог дуу шүлэг зохиох, зураг зурах, ном орчуулах, зохиол бичих ажлыг хийцгээж байжээ. Чухам ингэж амьдралынхаа дунд үе буюу 30-аад наснаасаа Манжийн дарангуйлал, тэдний гар хөл болсон монгол феодал ноёдын бурангуй амьдралыг шоглон эсэргүүцэж, ард олны амьдралын гүнд орж түүх судар зохиох болжээ. Нутгийн ардууд түүнийг «Эрхтэн дархтнаас айдаггүй, энгийн ардын эрхэм хүмүүсийг энэрэн хүндэлдэг» гэж ярьдаг байсан нь Инжинаашийн нийгмийн байр суурийг тодорхойлох нэгэн талын баримт мөн. Гэвч түүний тайж язгуурын гарал нь зохиол зохиоход арга буюу нөлөөлсөн болох нь олон талаар илт байна.

Хөх судар зохиол хэвлэгдэх боломжгүйгээс нилээд хугацаанд гар бичмэлийн байдлаар монголчуудын дотор ялангуяа Өвөр Монголд ихээр тархан дэлгэрч хадгалагдаж иржээ. 1938 онд Тэмхэтийн эрхэлж байсан Бээжин дэх Монгол бичгийн хэвлэлийн хорооноос тосон бараар гучдугаар бүлэг хүртэл 5 дэвтэр болгон хэвлэжээ. 1939 онд Буянхишигийн эрхэлж байсан Кайлу хот дахь Монгол бичгийн хорооноос жаран есөн бүлгийг нь арван хоёр дэвтэр болгон чулуун бараар хэвлэжээ. 1944 онд Чуулалт хаалга дахь Монгол судар бичгийн хүрээлэнгээс эрхлэн оршил, эхний 18 бүлгийг нэгэн дэвтэр болгон хорголжин бараар хэвлэн гаргажээ. 1957 онд Хөх хотод жаран есөн бүлгийг нь гурван дэвтэр болгон монголоор хэвлэжээ. Энэ бол анхны бүрэн эх мөн. Одоо Өвөр Монголд дахин хэвлэж байгаа сураг байгаа боловч бидний гарт хараахан ороогүй байна. Хөх судрыг хэвлүүлэх, эрж сурвалжилж бүрэн бүтэн болгох ажлыг Буянхишиг, Эрдэнэтогтох нар нилээд чармайлт гарган хийснийг тэмдэглүүштэй.

Хөх судар зохиолыг бичих ажил барагцаалбал 1830-аад оноос эхэлжээ. Инжинааш эцгийнхээ бичиж байсан зохиолыг 1870 оноос үргэлжлүүлэн бичсэн бололтой. Уул зохиолыг бичиж гүйцээхэд жар гаруй жилийн нөр их хөдөлмөр оржээ.

Хөх сударт 1162 оноос 1227 он хүртэл монголын түүхийн 62 жилийн үйл явдал хамрагджээ. Хөх судар зохиол бүгд 69 бүлэгтэйгээс 55 бүлэг нь Чингэс хааны үеийн хэрэг явдал, 14 бүлэг нь Өгөөдэй хааны үеийн хэрэг явдлыг бичжээ. Уг нь 120 бүлэгтэй байсан гэдэг нь үндэстэй ч байж болох. Яагаад гэвэл зохиолч номын нэрийг «Их Юан улсын мандсан төрийн Хөх судар» гэж нэрэлснээс үзвэл Юан гүрний үеийн монгол хаад, ялангуяа Хубилай хааны хэрэг явдлыг заавал бичсэн баймаар.

«Хөх судар» зохиол бол уран зохиолын хэллэгээр бичсэн монголын түүхийн томоохон зохиолын нэг юм. Өөрөөр хэлбэл «Гурван улсын түүх» зохиолын хэлбэрээр бичсэн монголын түүхийн зохиол. Гэвч бид уул зохиолыг цэвэр түүхийн роман гэж үзэж хараахан болохгүй мэт. Зохиолд түүхийн үнэн байдалд тулгуурлан түүхэн хүний үйл явдал, түүний эсрэг дүрүүдийг тухайн үедээ яг л тийм байсан байх гэмээр уран хэллэгээр дүрслэн бичсэн байдаг. Тэгэхдээ энэ бүх дүрслэлээ ардын доторхи аман зохиолын өв уламжлалыг түүхийн бодит үйл явдалтай нарийвчилан харьцуулан байж бүх дүрүүдийг гаргажээ.

Инжинааш бичсэн нь: «Их Юан улсын мандсан төрийн Хөх судрыг ...залгаж бүрэн болгон цөлбөн гаргаад монгол тоотон нийтээр мэдтүгэй хэмээн өдий удтал сэтгэсэн сэтгэл лүгээ нийцэж даруй эцэг ноёны цөлбөн бичсэн найман бүлгээс дотогш залган цөлбөн бичиж гаргаад манай монгол тоотонд түмэн үе хоцруулж монгол тоотон бүгдээр уг үндэс бэ язгуур удмаа мэдтүгэй хэмээн их Юан улсын харьяат арван зүйлийн

судар, бичиг, цэдэг, тууж, үлгэр, шасдир, тэмдэглэл... түүх цөм уудлан гаргаж нарийвчлан залгаж хянан нийцүүлэхүүеэ»⁴ хэмээжээ. Үүнээс үзэхэд маш удаан хугацаанд арвин их түүхийн хэрэглэгдэхүүн түшиглэн бичсэн болох нь тодорхой байна.

Хөх судрын нэгэн онцлог гэвэл ард түмний дотор ялангуяа монгол туургатны дотор тархсан монголын түүхийн холбогдолтой арвин их аман зохиолын санг өргөн ашиглаж монголын түүхийн бусад сурвалжид байхгүй шинэ соргог мэдээг олж бичсэн явдал юм. Иймээс монголын түүхийг судлахад Хөх судраас нөхөж бичиж болох түүхийн шинэ зүйл нилээд бий.

Зохиогч нь монгол хэл бичгээ гүнээ хүндэтгэн монголын түүхийн иж бүрэн зохиол бичихэд монгол үг хүрэлцэхгүй, хятадаар бичих гэдэг үзлийг эрс эсэргүүцэн монгол үг үсгийн утгыг эрж сурвалжлах ажлыг ихэд хичээнгүйлэн хийжээ. Зохиогч зохиолынхоо оршилд бичсэн нь: «Монгол үгийн нэрийг бичихэд ...тоолшгүй олон бэрхшээл тохиолдож...үнэн утга санааг эрэн... нэгэн хуучин монгол үгс гарч ирээд түүний утга санааг мэдэхгүйд хүрвээс хороо хүрээний хөгшин зэмдэг өвгөд эмгэдийг эрж... монгол үгсийг асууж айл хэсүүчлэхэд хүргэнэ... Ар газрын (Ар Монголын-Ч. Д) үгийн утгыг эрэн асуухуяа маш бэрх, харин хятад үсгийн учрыг нэхэмжлэхээс бэрхтэй болжээ...Манай газрын хянамгай үгүй ард (этгээдүүд) өөрөө өөрийн монгол үг ба үсгээ туйлд хүртэл хичээн хянах (оролдох) үгүй бөгөөд нэгэн хоёр иргэн (хятад) үсэг таниваас даруй монгол үсгээ басамжлан монгол үсгээр иргэний (хятадын) санааг бүртгэн гаргаж хэрхэн чадна хэмээн амны аяар чалчина»⁵ гэжээ. Үүнээс үзэхэд Инжинааш нь зохиолоо эх монгол хэлээрээ бичих гэж үлэмж их хөдөлмөр гаргасан нь тодорхой байна. Нэгэн зэрэг түүнд бүх монгол нутгаар ялангуяа Ар Монголоор явж монголын түүх, үгийн утга сурвалжлах боломж олдоогүй ажээ.

Инжинааш зохиолоо бичихдээ монгол, хятад, манж, төвд хэлний арвин ном, хэрэглэгдэхүүн ашиглаж, түүнд бас шүүмжилттэй ханджээ. Ялангуяа монголын түүхийн холбогдолтой хятад сурвалж бичгийг маш нарийн хянамгай ашиглажээ. Тэр «Тунцзянь ганьму» «Юан улсын судар» зэрэг хятад сурвалжийг ашиглахдаа нилээд шүүмжлэлтэй авч үзжээ. Жишээлбэл: «Тунцзянь ганьму» бичигт хятад хэрэг явдлыг хэт товойлгоод, Чингисийн хаан сууснаас өмнөх хэрэг явдлыг огт бичсэнгүй гэжээ. Юан улсын судрыг Мин улсын хятад сударч нар тэмдэглэсэн тул «хятад хүний өчүүхэн сэтгэл муу эхнэрийн бяцхан зангаа гэж чадсангүй» гэх мэтээр шүүмжлэн бичжээ.⁶

Хөх сударт дэлгэрэнгүй Оршлыг бичсэнээр зохиогч өөрийн үзэл санааг илтгэн гаргаснаас гадна зохиолыг уншихад ойлгомжтой болгожээ. Зохиогч оршлынхоо хэсэгт энгийн номхон ардын сайхан санаа, эрхэм нандин чанарыг уран үгээр бичиж, аливаа дайныг эсэргүүцэж энх амгаланг хүссэн жирийн ардуудыг нэн тодорхой тусган харуулжээ. Номын оршилд монголын өргөн олон ард түмэн ноёд феодалын хоорондын зөрчил болон ноёрхогч ангийн дотоод зөрчлийг их л оновчтой үгээр илчлэн бичжээ. Бас хятадын хагалан бутаргах бохир санааг битүү утгаар гаргаж, манж нар хятадад уусан хайлж байгааг хурцаар шүүмжилжээ. Манж нар монголыг байлдан эзлэх үеэр урваж бууж өгсөн монгол ноёд, тэдний угсаа нарыг шүүмжлэн бичсэн нь: «Бичиг хэмээбээс бичиг үзсэнгүй, цэрэг хэмээбээс цэрэг сурсангүй, нүд хамар ба гар хөл бас бусдаас илүү ургасангүй...ужид самуун харанхуй будангуй...эдгээр...ард ноёд тэдний гэр бүл толгойд элдэв зүйлийн эрдэнийн чулууны орой зүүж, малгайд таван өн-

⁴«Хөх судар», 13-р тал.

⁵«Хөх судар» 15-р тал.

⁶«Хөх судар» 38-р тал.

гийн тогосын отго хадаад, биед луут магнаг хувцад өмсөж бэлхүүсэнд цагаан хасын бүс бүсэлж, хүзүүнд оюу шүрийн эрээ хүзүүвчлэн, мөрдөө булга, үнэгэн дахыг нөмрөн...гар хөлдөө гэрэлтэй сонин алтан сувдыг эдлээд гарваас хээнцэр зарц...орвоос гуа шивэгчин...идэвээс долоон амтатын эрхэм идээ, унтваас арван харын ужид цэнгэл, авч үзвээс хувилгаан сахиулсны мэт өнгө гэрэлтэй, амтыг хэлэлцвээс албин чөтгөрийн амьсгал лугаа адил лагшим өмхий юм бий. Эдгээр юм хэмээгч нь...Дайчин улсын тулгур төр нээх үед цэрэгт зүтгэж гавьяа байгуулсан»⁷ ардын үр угсаа гэжээ. Инжинааш өөрийн зохиолдоо иймэрхүү манжийн төрд зарцлагдан үйлчилж байсан феодал ноёдын урвамтгай ажиллагааг хурцаар шүүмжилж бичжээ.

Инжинаашийн «Хөх судар» зохиол нь монголын түүх судлахад чухал хэрэгтэй хэрэглэгдэхүүн мөн боловч түүнийг огт шүүмжлэлгүй авч үзэж бас болохгүй. Зохиолч өөрийн зохиолд монголын феодалын ноёрхогч ангийн эрх ашиг ялангуяа. Чингис хааны үйл ажиллагааг хэт дэвэргэн магтсан тал байна. Тухайлбал зохиолд Чингис хаан аливаа асуудлыг шийдвэр лэхдээ ардчилстн аргыг баримталдаг, бусдын ов мэхэнд орж алдаа гар- гасан хүнийг уучилдаг, цэрэгтэйгээ хамт амьдарч, зовлон жаргалаа хамт эдэлж, хамтран зүтгэгчдийгээ туслан дэмждэг, улсын сан хөрөнгөөс морь, үхэр, хонь, арьс, ноос, бүс, цай гаргаж Жамухын цэрэгт эрсдэн хэлмэгдсэн ядуу зүдүү ардад олгосон гэх мэтээр бичсэн байдаг. Өөрөөр хэлбэл Чингис хааны үйл ажиллагаанд өчүүхэн ч буруу зүйл байгаагүй гэдэг үзлээр бичиж, Чингисийн харь улсад хийсэн түрэмгий дайн, эвдэн сүйтгэсэн ажил явдлын талаар нэг ч зэмэлсэн үг бичээгүй байна. Ер нь зохиолыг Чингисийн «алтан ургийн үзэл» гэгчээр бичиж, Чингисийн үйл ажиллагааг хэт товойлгон магтсан байна.

Инжинаашийн «Хөх судар» бичигдсэнээс хойш 90 жил болж энэ хугацаанд монгол туургатны дотор ихэд дэлгэрэн тархаж, монголын түүх судлаачдын анхаарлыг ихэд татаж ирэв. Монголын түүхийн судлалд ч үнэгэй хувь нэмэр оруулж ирсэн ба оруулсаар байна.

⁷«Хөх судар», 26—27-р тал.